



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

“Хөрөнгө зарцуулах” тухай 83 дугаар тушаалд  
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хууль 14.2.3, 14.2.5 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газраас 2016 оныг хэрэглэгчдийн эрх ашгийг дээдлэх жил болгон уриалга гаргасантай уялдуулан Эрүүл мэнд, спортын яамны 2016 оны төсөвт тусгагдсан эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг доорх хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсугай.

2. 2.1 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чадавхийг сайжруулахад шаардлагатай байгаа багийн эмч нарын мотцикл худалдан авахад 300.0 сая,

2.2 Улсын хэмжээнд 3-64 насны иргэдийн бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тодорхойлох сорилыг орон даяар зохион байгуулах, биеийн тамир, спортын төрлүүд идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих, сурталчлах бусад үйл ажиллагаанд 400.0 сая,

2.3 “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 21 аймаг, 330 сум, нийслэлийн 152 хорооны хэрэглэгчидийн Нийтийн эрүүл мэндийг дэмжихэд шаардлагатай спортын үйл ажиллагааг улс орон даяар зохион байгуулах, сургалт зохион байгуулах, сурталчилах, сурталчилгааны материалын хангамж хүртээмжийг бий болгоход 1,300.0 сая

3. Энэхүү үйл ажиллагааны 2.2, 2.3 –д заасан төслийн удирдамж, төсвийг сайдаар батлуулан зохион байгуулж ажиллахыг Биеийн тамир, спортын хөгжлийн төв /Жаргалсайхан/, Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг сайжруулах ажлыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080564